



**Оюу толгой ХХК**

**Боловсон хүчин, бүтэц, зохион байгуулалтын хэлтэс**

**ХН-Ж7.1: Кэмпийн дотоод журам, ёс зүйн дүрэм**

## Агуулга

I Ерөнхий зүйл.....	3
1. Журмын дугаар, нэр.....	3
2. Зорилго.....	3
3. Үйлчлэх хүрээ.....	3
4. Журмын хэл.....	3
5. Хүчин төгөлдөр болох.....	3
6. Эрх хэмжээ ба удирдлага.....	3
II Журам.....	4
7. Журмыг дагаж мөрдөх.....	4
8. Ёс зүйн хэм хэмжээ.....	4
9. Ёс зүйн зохистой хэм хэмжээ.....	4
10. Ёс зүйд зохисгүй хэм хэмжээ.....	5
11. Кэмпид ирэх, буцах.....	7
11.1. Нисэх буудал, нислэг.....	7
11.2. Кэмпид ирэх.....	7
11.3. Кэмпээс буцах.....	8
12. Уурхайн талбар дахь байрны хангамж.....	9
12.1. Зөвшөөрөл.....	9
12.2. Байрны хуваарилалт.....	9
12.3. Кэмпид байрлагсдад үзүүлэх хангамж, үйлчилгээ.....	10
12.4. Амрах, унтах.....	10
12.5. Байрны аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал.....	11
13. Амралт чөлөөт цаг өнгөрүүлэх газрууд.....	12
14. Хоол хүнсний үйлчилгээ.....	12
15. Эрүүл мэнд, эрүүл ахуй.....	13
16. Аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал.....	14
16.1. Ерөнхий зүйл.....	14
16.2. Уурхайн талбарт оруулахыг хориглосон зүйлс:.....	14
16.3. Тээврийн хэрэгсэл жолоодох.....	15
16.4. Аюулгүй байдал.....	16
16.5. Онцгой байдал.....	17
17. Холбоо барих утасны дугаар.....	18
18. Үүрэг, хариуцлага.....	18
18.1. Ажилтны үүрэг.....	18
18.2. Удирдах ажилтны үүрэг.....	19
18.3. Гэрээт компани болон бусад этгээдийн үүрэг.....	19
III Хавсралт.....	21
19. Нэр томъёо.....	21
20. Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж.....	21
21. Журамд холбогдох мэдээлэл.....	22

# I Ерөнхий зүйл

## 1. Журмын дугаар, нэр

1.1. Энэхүү журмыг ХН-Ж7.1. Кэмпийн дотоод журам, ёс зүйн дүрэм гэж нэрлэнэ.

## 2. Зорилго

2.1. Энэхүү журмын зорилго нь Оюу толгой ХХК (цаашид “Компани” гэх) - ийн уурхайн талбар, кэмп, нисэх буудал, бусад холбогдох барилга байгууламж, байранд байрлаж, ажиллаж, түр буудаллаж эсхүл үйлчлүүлж байгаа хүн бүрт аюулгүй, найдвартай, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан, найрсаг, тааламжтай орчныг бүрдүүлэхэд оршино.

2.2. Энэхүү журамд Компанийн уурхайн талбар, нисэх буудал, кэмп, бусад холбогдох барилга байгууламж, байранд байрлаж, ажиллаж, зочилж эсхүл үйлчлүүлж буй хүн бүрийн дагаж мөрдөх журам болон ёс зүйн хэм хэмжээний талаар тодорхой тайлбарласан болно.

## 3. Үйлчлэх хүрээ

3.1. Энэхүү журам нь Компанийн уурхайн талбар, нисэх буудал, кэмп, бусад холбогдох барилга байгууламж, байранд байрлаж, ажиллаж, түр буудаллаж эсхүл үйлчлүүлж байгаа Компанийн ажилтнууд (Үүнд: дадлагажигч орно), гэрээт компани, тэдгээрийн ажилтнууд, гэрээлэгч, зочид гэх зэрэг бүх хүмүүст хамаарч үйлчилнэ.

## 4. Журмын хэл

4.1. Энэхүү журмыг Монгол, Англи хэл дээр боловсруулсан бөгөөд Монгол, Англи хэл дээрх хувилбаруудын хооронд ойлголтын зөрүү гарвал Монгол хувилбарыг баримтлан тайлбарлана.

## 5. Хүчин төгөлдөр болох

5.1. Энэхүү журмыг 2017 оны 10 дугаар сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

## 6. Эрх хэмжээ ба удирдлага

6.1. Шаардлагатай тохиолдолд энэхүү журмыг шинэчилж болно.

6.2. Боловсон хүчин, бүтэц зохион байгуулалт хариуцсан Ерөнхий менежер нь энэхүү журмыг хариуцна. Энэхүү журамд нэмэлт өөрчлөлт оруулах аливаа саналыг дээр дурдсан албан тушаалтанд хандан гаргах бөгөөд уг албан тушаалтан нь зохих журмын дагуу хянан батлуулна.

## II Журам

### 7. Журмыг дагаж мөрдөх

**7.1.** Энэхүү журмыг дагаж мөрдөх нь Оюу толгой уурхайн талбар (цаашид “уурхайн талбар”)–т нэвтрэн орох, байрлахад шаардагдах үндсэн нөхцөл болно. Уурхайн талбарт нэвтрэх, байрлах хүн бүрт энэхүү журмын талаар ерөнхий мэдээлэл өгөх ба Компанийн ажилтнууд (Үүнд: дадлагажигч орно), гэрээт компани, тэдгээрийн ажилтнууд, гэрээлэгч болон зочин нь энэхүү журмыг дагаж мөрдөх үүрэгтэй.

**7.2.** Энэхүү журмыг уурхайн талбар дахь ажлын ба ажлын бус орчин, албан өрөө тасалгаа зэрэг бүх газарт дагаж мөрдөнө. Үүнд: байрлагсдын унтаж амрах байр, байрны орчин, зоогийн газар, хүн оршин суудаггүй сул чөлөөтэй газар, амралт чөлөөт цаг өнгөрүүлэх болон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулах газрууд, Оюу Толгой дахь нисэх буудал гэх мэт багтана. Түүнчлэн энэхүү журам нь уурхайн талбараас ирэх, буцах компанийн тээврийн хэрэгсэлд нэгэн адил үйлчилнэ.

**7.3.** Энэхүү журмыг зөрчсөн байж болзошгүй эргэлзээтэй буюу сэжигтэй тохиолдлыг холбогдох эрх бүхий этгээд хянаж шалгана. Хянаж, шалгаад зөрчил гаргасан нь тогтоогдсон тохиолдолд тухайн зөрчлийн шинж чанараас хамааруулан ажилтанд зохих сахилгын шийтгэл ногдуулах эсхүл уурхайн талбараас гаргах арга хэмжээ авч болно.

**7.4.** Гэрээт компанийн ажилтан энэхүү журмыг зөрчсөн тохиолдолд Компани нь уг зөрчлийн талаар тухайн гэрээт компанид мэдэгдэнэ. Зөрчил гаргасан нь тогтоогдсон тохиолдолд зөрчлийн шинж чанараас хамааран гэрээт компанийн ажилтныг уурхайн талбараас гаргах, цаашид нэвтрэхэд хязгаарлалт тавьж болно. Уурхайн талбараас гаргах ажлыг гэрээт компани хариуцан зохион байгуулна.

### 8. Ёс зүйн хэм хэмжээ

**8.1.** Уурхайн талбарт байрлаж буй ажилтан болон зочин нь тэнд ажиллаж амьдарч буй бусад хүмүүстэй хүндэтгэлтэй, эвтэй, найрсаг байх ёс зүйн хэм хэмжээг баримтална.

### 9. Ёс зүйн зохистой хэм хэмжээ

**9.1.** Ёс зүйн зохистой хэм хэмжээг баримтлах зарчим нь хувь хүн бусдыг өөртэйгээ хэрхэн харилцахыг хүсдэг, үүнтэй адилаар бусдыг хүндэтгэн харилцах явдал юм. Ёс зүйн зохистой хэм хэмжээнд дор дурдсан зарчмууд багтах ба үүгээр хязгаарлагдахгүй болно. Үүнд:

9.1.1. Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Компанийн эрхэм зорилго, алсын хараа, үнэт зүйлс, “Бидний ажлын арга барил” болон Компанийн бусад бодлого, дүрэм, журам, стандартад нийцүүлэн биеэ авч явах;

9.1.2. Бусад хүмүүстэй эелдэг, боловсон харилцах;

9.1.3. Бусдын хувийн орон зай, хувийн нууц, амгалан тайван орчинд амрах эрхийг хүндэтгэн хангах;

9.1.4. Хоол хүнс, уух зүйл, хувцаслалт зэрэгт бусдын сонголтыг хүндэтгэх;

9.1.5. Бусдын соёл, шашин шүтлэгт хүндэтгэлтэй хандах;

9.1.6. Хувийн болон нийтийн ариун цэвэр, эрүүл ахуйг сахих;

9.1.7. Ажлын байранд холбогдох ажлын хувцас, хувийн хамгаалах хэрэгслийг хэрэглэх, ажлын бус хэсэгт ямагт аюулгүй, эрүүл ахуйн шаардлага хангах байдлаар хувцаслах.

## **10. Ёс зүйд зохисгүй хэм хэмжээ**

**10.1.** Дараах зөрчлүүдүүдээс аль нэгийг гаргасан тохиолдолд ноцтой зөрчилд тооцох ба Компанийн ажилтанд ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулна. Үүнд:

10.1.1. Хүний биед аливаа гэмтэл учруулах, эд хөрөнгөд хохирол учруулах;

10.1.2. Компанийн өмч хөрөнгө, байгаль орчинд санаатайгаар хохирол учруулах, сүйтгэх. Үүнд: Байгаль орчинд болон Компанийн тоног төхөөрөмжинд хор хохирол учруулах (гэхдээ үүгээр хязгаарлагдахгүй) үйлдэл, эс үйлдэл зэрэг багтана. Тухайн үйлдэл, эс үйлдэхүй нь захиргааны зөрчил эсхүл гэмт хэрэг байхаас үл хамааран сахилгын шийтгэлийг ногдуулна.

10.1.3. Бусдын эсрэг хүч хэрэглэх, бусдын бие махбодид халдах;

10.1.4. Бусдын өмчлөлийн зүйлийг зөвшөөрөлгүй авах, бусдын эд зүйлийг ажлын байр, Уурхайн талбар (Үүнд: Нисэх онгоцны буудал хамаарна)-аас гаргах, гаргахыг завдах;

10.1.5. Галын хор болон галаас урьдчилан сэргийлэх тоног төхөөрөмж, гал унтраах бусад хэрэгслийг санаатайгаар салгах, унтраах, эвдэх, шаардлагагүй тохиолдолд оролдох;

10.1.6. Уурхайн талбарт зөвшөөрөлгүйгээр гадны хүн оруулах, гаргах, орох, гарахад нь туслах, зөвшөөрөлгүйгээр орсон, гарсан тухай зөрчлийг мэдээлэхгүй байх;

10.1.7. Бүх төрлийн мөрийтэй тоглоом тоглох;

10.1.8. Хууль бус аливаа үйл ажиллагаа явуулах;

10.1.9. Аливаа хэлбэрээр бэлгийн дарамт үзүүлэх: Бэлгийн дарамт гэж аливаа этгээдийг хүсээгүй буюу хүлээн зөвшөөрөөгүй байхад бэлгийн сэдлийн улмаас аливаа байдлаар түрэмгийлсэн, доромжилсон, айлган сүрдүүлсэн шинжтэй үйлдлийг ойлгоно. Бэлгийн дарамт нь дараах хэлбэрээр илрэх бөгөөд үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

10.1.9.1. Бэлгийн дур хүслээ хангах сэдлээр ил эсвэл далдуур байдлаар дарамт, шахалт үзүүлэх;

10.1.9.2. Ширтэн харах, чимхэх, биед хүрэх зэрэг бие махбодын зохисгүй үйлдлүүд болон хэт их танимхайрах байдал гаргах;

10.1.9.3. Хүсээгүй байхад бэлгийн харилцаанд орохыг санал болгох/хүсэлт тавих;

10.1.9.4. Хүний хувийн амьдралын тухай асуулт асуух буюу худал цуу үг тараах;

10.1.9.5. Садар самуун үг хэллэг хэрэглэх, хошигнох, наргих болон далдуур аргаар садар самуунд уруу татах;

10.1.9.6. Нэр хоч өгөх;

10.1.9.7. Хүнийг гутаан доромжилсон зураг, наадаг зураг, хүүхэлдэйн кино буюу шог зураг, сараачмал зураг, цахим шуудангийн хавсралт, схем зураг, хуанли зэрэг материалыг үзүүлэх, тараах (цахим хэлбэрээр дамжуулсан материалыг мөн хамруулна)

10.1.10. Ажилтан ажлын байранд согтуурсан, мансуурсан байдалтай байх. Согтууруулах ундаа хэрэглэсэн гэх сэжиг илэрсэн тохиолдолд “Мансууруулах бодис ба согтууруулах ундааны хэрэглээг зохицуулах журам”-ын дагуу арга хэмжээ авна.

10.1.11. Аливаа байдлаар бусдыг ялгаварлан гадуурхах, дарамтлах, гадуурхсан, дарамталсан хүнтэй нэгдэн бүлэглэсэн байх эсхүл бусдыг өөгшүүлсэн, дэмжсэн байх.

**10.2.** Дараах зөрчлийг гаргасан тохиолдолд тухайн зөрчлийн шинж чанараас хамааруулан Компанийн ажилтанд ажлаас халах хүртэл сахилгын шийтгэл ногдуулж болно.

10.2.1. Галын дохиолол идэвхжсэн үед нүүлгэн шилжүүлэлтэд хамрагдахгүй байх буюу өөрийн өрөө/ гэрээс даруй гарч цуглах цэгт очихгүй байх;

10.2.2. Шүлсээ хаях, зориулалтын бус газар бие засах, суултуурын гадуур болон усны сав зэрэг бусад саванд бие засах;

10.2.3. Бусадтай харилцахдаа айлган сүрдүүлэх, түрэмгий зан авир гаргах, заналхийсэн шинж чанар бүхий үг хэллэг ашиглах, үйл хөдлөл үзүүлэх, зохисгүй байдлаар бусдын биед хүрэх;

10.2.4. Хүний нэр төрийг гутаан доромжлох, цуурхал тараах;

10.2.5. Кэмгийн өдөр тутмын үйл ажиллагаа, аюулгүй байдал, аюулгүй ажиллагаа, кэмпид байрлах ажилтан, зочдын амгалан тайван байдал, кэмгийн соёл, хувь хүний эрх, эрх чөлөөнд саад болохуйц үдэшлэг, уулзалт, цуглаан болон бусад арга хэмжээг зөвшөөрөлгүйгээр зохион байгуулах;

**10.3.** Энэ журмын 10.1 болон 10.2-т заасан зөрчлүүдийг гаргасан тохиолдолд компанийн ажилтнуудаас бусад ажилтнууд болон зочдын хувьд уурхайн талбараас гаргах хүртэл арга хэмжээг авах үндэслэл болно.

## **11. Кэмпид ирэх, буцах**

### **11.1. Нисэх буудал, нислэг**

11.1.1. Нисэх онгоцоор зорчиж буй хүмүүс биеийн байцаалтаа нисэх буудлын шалган нэвтрүүлэхэд заавал үзүүлэх үүрэгтэй.

11.1.2. Зорчигчид нь аюулгүй байдлын шаардлага, нисэх баг, нислэгийн компани болон нисэх буудлын ажилтнуудаас өгсөн зааварчилгаа, дүрэм журмыг дагаж мөрдөх үүрэгтэй.

11.1.3. Нислэг эхлэхээс өмнө зорчигчдыг болон тэдний ачаа, гар тээшийг нисэхийн аюулгүй байдлыг хангахын тулд шалгана. Энэхүү аюулгүй байдлыг хангах шалгалтыг Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй иргэний нисэхийн дүрэм, журмын дагуу гүйцэтгэнэ. Шалгалтыг металл илрүүлэгч, рентгэн сканнер болон хяналтын бусад техник хэрэгсэл ашиглаж явуулна. Түүнчлэн хүний биед биечлэн нэгжлэг, шалгалт хийж болно. Оюу Толгой дахь нисэх буудалд ирэхэд бүх зорчигчид болон ачаа тээшинд дахин нэмэлт үзлэг хийнэ.

11.1.4. Үзлэг шалгалтын үеэр нэвтрүүлэхийг хориглосон эд зүйлс, бодис илэрсэн тохиолдолд аюулгүй байдал хариуцсан хэлтэст мэдэгдэх ба тухайн хэлтэс нь холбогдох албаны бусад хүмүүст мэдэгдэнэ.

11.1.5. Оюу Толгой дахь нисэх буудал болон уурхайн талбарын хооронд автобусаар үйлчилнэ.

### **11.2. Кэмпид ирэх**

11.2.1. Зөвхөн зөвшөөрөлтэй ажилтан болон зочныг уурхайн талбарт нэвтрүүлнэ. Ажилтан болон зочин нь нэг ба түүнээс дээш хоногоор уурхайн талбарт байрлах тохиолдолд зохих зөвшөөрлийг урьдчилан авсан байна. Уурхайн талбарт зорчих хүн бүр очихоосоо өмнө эсхүл очсон даруйдаа шаардагдах сургалтад заавал хамрагдана.

11.2.2. Уурхайн талбарт байрлах бүх ажилтан болон зочин нь ирсэн даруйдаа Кэмп, Уурхайн талбарын үйлчилгээний хэлтэст бүртгүүлнэ.

11.2.3. Зочин уурхайн талбарт нэвтрэхдээ өөрийн фото зураг бүхий бичиг баримттай байх шаардлагатай ба зочныг уурхайн талбарт нэвтрэх үед хүлээн авч дагалдан явах үүрэг бүхий ажилтан заавал байлцана. Зочин нь уурхайн талбарт байх хугацаандаа Компаниас олгосон Зочны үнэмлэхийг харагдахуйц газар байнга зүүх ёстой ба Компанийн холбогдох ажилтан тэднийг байнга дагалдаж явна.

### **11.3. Кэмпээс буцах**

11.3.1. Кэмпээс буцахдаа ажилтан болон зочин нь ажлын болон зочны үнэмлэхээ төхөөрөмжид уншуулан бүртгүүлж гарна. Зочин нь Кэмп, уурхайн талбарын үйлчилгээний хэлтэст зочны үнэмлэхээ буцаан хураалгах ба ажилтан болон зочин нь өрөө/гэрийн түлхүүрээ хүлээлгэн өгнө. Кэмп, Уурхайн талбарын үйлчилгээний хэлтэс нь Кэмпээс буцаж буй ажилтан ба зочдод нисэх буудал хүртэл унаагаар үйлчлэх бөгөөд хөдлөх цагийг урьдчилан мэдэгдэнэ.

11.3.2. Кэмпид байрлах ажилтан нь амралт болон богино хугацааны чөлөөгөөр кэмпээс түр гарах тохиолдолд өрөө/гэрийг эмх цэгцтэй үлдээнэ. Хаалгыг цоожилж, түлхүүрийг Кэмп, уурхайн талбарын үйлчилгээний хэлтэст үлдээнэ. Компани нь хувийн эд зүйлсийг найдвартай хадгалж хамгаалахад бүхий л талаар анхаарал тавьж ажиллах боловч эд зүйлс алдагдах, эвдрэх тохиолдолд хариуцлага хүлээхгүй.

11.3.3. Ажилтан болон зочин нь өөрийн орон байрыг зохисгүй ашиглан, эвдэж сүйтгэсэн, хайхрамжгүй хандсаны улмаас Компанид хохирол учруулсан тохиолдолд энэхүү зөрчилд үзлэг, шалгалт хийгдэх хугацаанд тухайн ажилтны уурхайн талбараас явах хугацааг түр хойшлуулж болно. Хэрэв зөрчил (эвдрэл, гэмтэл) нь тухайн ажилтны буруутай үйл ажиллагаанаас эсхүл хайхрамжгүй байдлаас үүдэлтэй нь тогтоогдсон бол учирсан хохирлыг тухайн ажилтан Компанид нөхөн төлөх үүрэгтэй.

11.3.4. Уурхайн талбарт байрлаж буй ажилтан нь уурхайн талбараас ажлын зорилгоор түр хугацаагаар гарах тохиолдолд өөрийн шууд удирдлагад гарах болсон шалтгаан, буцаж ирэх хугацаа, очих газрын талаар бичгээр (утас, имэйл гэх мэт) мэдэгдэж зөвшөөрөл авна.

11.3.5. Уурхайн талбарт байрлаж буй ажилтан нь уурхайн талбараас ажлын бус цагаар, хувийн зорилгоор түр хугацаагаар гарах тохиолдолд өөрийн шууд удирдлагад гарах болсон шалтгаан, буцаж ирэх хугацаа, очих газрын талаар бичгээр (утас, имэйл гэх мэт) мэдэгдэнэ. Энэ тохиолдолд ажилтан өөрийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлаа бүрэн хариуцна.



## 12. Уурхайн талбар дахь байрны хангамж

### 12.1. Зөвшөөрөл

12.1.1. Зөвхөн зөвшөөрөл бүхий ажилтан болон зочныг уурхайн талбарт байрлах, хоноглохыг зөвшөөрнө. Зочид болон Оюу Толгой төсөлд харьяалагдахгүй бусад хүмүүс нь уурхайн талбарт ирэхээсээ өмнө байрны зөвшөөрлөө урьдчилан авах ёстой.

### 12.2. Байрны хуваарилалт

#### 12.2.1. Ерөнхий мэдээлэл

12.2.1.1. Уурхайн талбарт байрлах ажилтнууд болон зочдыг ажиллах хугацаанд нь байрлах байраар хангана. Байрны хуваарилалтыг Кэмп, Уурхайн талбарын үйлчилгээний хэлтэс хийнэ. Байрны хүртээмжтэй байдал, бизнесийн шаардлага зэргээс шалтгаалан байрны хуваарилалт тухай бүр өөрчлөгдөж болно.

12.2.1.2. Ажилтнуудын байрны хуваарилалтыг дараах хүснэгтэд заасны дагуу албан тушаалын зэрэглэлийг үндэслэн хийнэ.

Байрны хуваарилалт	Албан тушаалын зэрэглэл
Дотроо угаалгын өрөөтэй 1 ортой өрөө/гэр	К болон түүнээс дээш зэрэглэл
Дундын угаалгын өрөөтэй, 2 ортой өрөө Нийтийн угаалгын өрөөтэй, 2 ортой өрөө	L зэрэглэл
Дундын / Нийтийн угаалгын өрөөтэй, 3 ортой өрөө Нийтийн угаалгын өрөөтэй, 3 ортой гэр	M зэрэглэл
Дундын/Нийтийн угаалгын өрөөтэй, 3 ортой өрөө Нийтийн угаалгын өрөөтэй, 4 ортой гэр	N болон түүнээс доош зэрэглэл

12.2.1.3. Зочдын болон зарим ажилтны байрлах байрыг тодорхойлох боломжгүй тохиолдолд Кэмп, Уурхайн талбарын үйлчилгээний хэлтэс хуваарилах асуудлыг хариуцан шийдвэрлэнэ.

#### 12.2.2. Гэрлэсэн хосуудад зориулсан байр

12.2.2.1. Компани нь гэрлэлтээ батлуулсан хосуудыг цөөн тооны байраар хангана. Эдгээр байранд орох хүсэлтэй хосууд Кэмпийн үйлчилгээний хэлтэст хандан өргөдөл гаргах ба нотариатаар батлуулсан гэрлэлтийн баталгааны хуулбарыг хавсаргана. Байрны хүрэлцээг харгалзан хүсэлтийг шийдвэрлэх бөгөөд хосуудад зориулсан байр хүрэлцээгүй тохиолдолд тэднийг хүлээлтийн жагсаалтад бүртгэнэ.

12.2.2.2. Кэмгийн орон байрны ашиглалтыг сайжруулах үүднээс хосуудын ажлын ростер буюу хуваарийг ижилсүүлэн зохицуулахыг компанийн зүгээс шаардаж болно.

12.2.2.3. Хэрэв хосууд тусдаа амьдрах эсхүл салах тохиолдолд тухайн байрыг суллаж өгөх үүрэгтэй.

12.2.2.4. Энэ талаарх дэлгэрэнгүй зохицуулалтыг Гэрлэсэн хосуудад зориулсан байрны талаарх журамд тусгасан болно.

### **12.2.3. Сул байрыг ашиглах**

12.2.3.1. Кэмпид байнга байрладаг эсхүл уурхайн талбарт тогтмол ирдэг зочдыг эзгүй байх хугацаанд өрөөг нь Кэмп, Уурхайн талбарын үйлчилгээний хэлтэс түр хугацаагаар ирж буй зочдод хуваарилж болно.

### **12.3. Кэмпид байрлагсад үзүүлэх хангамж, үйлчилгээ**

12.3.1. Хуваарилагдсан бүх байранд нүүр гарын алчуур, ор, гудас, дэр, дэрний уут, орны цагаан хэрэглэл, хөнжил байна. Байрны хуваарилалт хийгдэхэд өрөө/гэр эзэмшигч нь эдгээр хэрэглэлийг хүлээн авч бүрэн бус байгаа тохиолдолд Кэмгийн үйлчилгээний хэлтэст мэдэгдэх ба тэдгээрийг цэвэрхэн эдэлж хэрэглэн үлдээнэ.

12.3.2. Кэмгийн үйлчилгээний ажилтнууд орны цагаан хэрэглэл, нүүр гарын алчуур зэргийг солих ба байрыг хуваарийн дагуу цэвэрлэнэ. Өрөө/гэр эзэмшигч нь дараагийн хуваарьт цэвэрлэгээ хүртэл өрөө/гэрийнхээ цэвэр цэмцгэр байдлыг хариуцна. Кэмгийн үйлчилгээний хэлтэст хүсэлт гаргаж өрөө/гэрээ цэвэрлэх цэвэрлэгээний бодис, хэрэгсэл авах боломжтой. Өрөө/гэрийн цэвэрлэгээний ажлыг хөнгөвчлөх үүднээс кэмпид байрлагсдыг эд зүйлс, хувцасаа эмх цэгцтэй, далд байлгахыг шаардаж болно.

12.3.3. Кэмгийн цэвэрлэгээний ажилтнууд ариун цэврийн өрөө, хүн олноор цуглардаг газруудыг өдөр бүр цэвэрлэнэ. Ажилтан болон зочин нь шүршүүр, угаалгын өрөө, бие засах өрөөг соёлтой боловсон ашиглаж эрүүл ахуй, ариун цэврийг сахих үүрэгтэй.

12.3.4. Хувцас угаалгын үйлчилгээг үзүүлэх боловч кэмп дэх байршлаасаа хамаарч ажиллах өдөр нь өөр өөр байж болно. Өрөө/гэрийн дугаарыг тэмдэглэсэн угаалгын уут, бөглөх маягтыг байрлагсад олгоно. Зөв бөглөсөн цэвэрлэгээний маягтыг үндэслэн уутанд хийсэн хувцсыг угаалганд авч цэвэрлэн өрөө/гэрүүдэд буцааж тавина.

### **12.4. Амрах, унтах**

12.4.1. Уурхайн талбарын үйл ажиллагаа долоо хоногийн өдөр бүр 24 цагаар тасралтгүй үргэлжилдэг. Үүнтэй холбоотойгоор зарим ажилтнууд өдрийн цагаар ажиллаж, шөнө амардаг бол зарим нь шөнийн цагаар ажиллаж өдөр унтаж амрах шаардлагатай

байдаг. Иймд бүх хүмүүс ажилчдын байр, гэрүүдийн орчимд байхдаа бусдын амар тайван унтаж амрах эрхийг хүндэтгэн хоногийн 24 цагийн турш бусдад саад болохоор чимээ шуугиан гаргахгүй байх үүрэгтэй. Үүнд:

12.4.1.1. Ажилтнуудын унтаж амардаг газруудад чимээ шуугиан гаргахгүй байх;

12.4.1.2. Хаалга нүдэхгүй байх, унтаж амардаг газруудад чанга орилж хашгирах буюу гүйж харайхгүй байх;

12.4.1.3. Зурагт, хөгжмийн дууг намсгаж тохируулах;

12.4.1.4. Үзвэр үйлчилгээ, спортын болон нийтийг хамарсан арга хэмжээ, хурал зөвлөгөөнийг зөвшөөрөгдсөн газруудад зохион байгуулна.

## **12.5. Байрны аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал**

12.5.1. Байрны буюу өрөө, гэрийн түлхүүрийг ажилтан болон зочдод олгодог. Хэрэв түлхүүрээ гэсэн тохиолдолд Кэмп, Уурхайн талбарын үйлчилгээний хэлтэст нэн даруй мэдэгдэж, шинэ түлхүүр авна.

12.5.2. Ажилтан болон зочин өрөө/гэрийнхээ эд хогшил, тавилгыг зохих ёсоор ашиглах, арчлах үүрэгтэй. Хувийн эд зүйлсийг даатгалд хамруулдаггүй тул өрөө/гэртээ үнэт эдлэл, зүйлсийг орхихгүй байх нь зүйтэй. Компани өрөө/гэрт үлдээсэн хувийн үнэ бүхий зүйл болон бусад зүйлс алдагдсан тохиолдолд аливаа үүрэг хариуцлага хүлээхгүй.

12.5.3. Ажилтан болон зочин нь кэмийн байр болон нийтийн эзэмшлийн газар аливаа засвар үйлчилгээ хийлгэх шаардлага гарсан тохиолдолд Кэмп, Уурхайн талбарын үйлчилгээний хэлтэст мэдэгдэх үүрэгтэй. Тухайн асуудал нь аюулгүй ажиллагаа эсхүл аюулгүй байдалтай холбоотойгоор яаралтай арга хэмжээ авах шаардлагатай тохиолдолд өөрийгөө болон бусдыг эрсдэлд оруулахгүйгээр аюулыг зогсоох зорилгоор боломжит, зохих ёсны алхмыг авч энэ талаар Кэмп, Уурхайн талбарын үйлчилгээний хэлтэст нэн даруй мэдэгдэнэ. Засвар үйлчилгээ болон онцгой байдлын үед холбоо барих утасны дугааруудыг байрны хаалган дээр байрлуулсан байна.

12.5.4. Кэмп, Уурхайн талбарын үйлчилгээний хэлтсээс урьдчилж зөвшөөрөл авалгүйгээр аливаа цахилгаан тоног төхөөрөмжийг холбох, тавилгыг нэмж тавихыг хориглох ба хувийн цахилгаан тоног төхөөрөмж нь цахилгааны зохих шаардлагуудыг хангасан байх ёстой. Үсний сэнс, зөөврийн тенг (халаагуур), зурагт, радио, хөгжим тоглуулагч зэрэг хувийн цахилгаан хэрэгслийг ашиглах, суурилуулахдаа Кэмп, Уурхайн талбарын үйлчилгээний хэлтсээс зөвшөөрөл авна.

12.5.5. Кэмпид байрладаг эрэгтэй ажилчид болон зочдыг ямар ч үед эмэгтэйчүүдийн байранд нэвтрэх эсхүл байрны орчмоор сэлгүүцэхийг хориглоно.

### **13. Амралт чөлөөт цаг өнгөрүүлэх газрууд**

13.1. Уурхайн талбар дээр ажилтнуудыг амралт, чөлөөт цагаа өнгөрүүлэх байр, тоног төхөөрөмжөөр хангана. Компаниас эдгээр байр, тоног төхөөрөмжийн ажиллах цагийн хуваарь, ашиглах дүрмийг боловсруулан гаргаж, шаардлагатай үед шинэчилж байна.

13.2. Бие махбодид гэмтэл учруулах эрсдлийг багасгах, эд хөрөнгөд эвдрэл гарахаас сэргийлэх үүднээс Кэмпид байрлах ажилтнууд болон зочид нь эдгээр байр, байгууламж, тоног төхөөрөмжийг зориулалтын дагуу ариг гамтай эдэлж, зохистой хэрэглэнэ. Ялангуяа, тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу, зөвхөн үндсэн зориулалтаар нь ашиглана. Биеийн тамир, спортын төвүүдээр үйлчлүүлэхдээ зориулалтын хувцас, гутал өмсөх ба ажлын гуталтай үйлчлүүлэхийг хориглоно. Эдгээр байр болон тоног төхөөрөмжид эвдрэл, гэмтэл гарсан бол даруй Кэмп, Уурхайн талбарын үйлчилгээний хэлтэст мэдэгдэх ёстой.

13.3. Диско үдэшлэг, караоке, дуу хөгжмийн хамтлаг, тоглолт зэрэг тусгай арга хэмжээг Кэмп, Уурхайн талбарын үйлчилгээний хэлтэс зохион байгуулж болно. Хувь хүн болон багаараа бусад төрлийн арга хэмжээ болон нийтийг хамарсан арга хэмжээ зохион байгуулахдаа Кэмп, Уурхайн талбарын үйлчилгээний хэлтсээс зөвшөөрөл авна. Эдгээр арга хэмжээг зохион байгуулахдаа кэмпид байрлаж буй олон хүний эрх ашгийг харгалзан зохион байгуулна. Кэмпид байрлах бусад ажилчид болон зочдыг унтаж, амрахад саад болох аливаа арга хэмжээг зохион байгуулахыг үл зөвшөөрнө.

### **14. Хоол хүнсний үйлчилгээ**

14.1. Уурхайн талбарт ажилтнуудад зориулсан зоогийн газруудыг ажиллуулна. Ажилтнуудын зоогийн газар нь зөвхөн ажилтан болон эрх бүхий зочдод үйлчилнэ. Харин Оюу Толгой төсөлд хамаарахгүй зочид болон гадны бусад хүмүүс зоогийн газруудад төлбөртэй үйлчлүүлнэ.

14.2. Хоолны үйлчилгээ үзүүлэх гэрээт компани нь хүмүүсийн нийтлэг сонирхолд нийцсэн зохих стандарт, шаардлага хангасан хоолоор үйлчилнэ.

14.3. Уурхайн талбарт байрлах ажилтнууд болон зочдын гүйцэтгэж буй ажил үүрэг, оршин суугаа байршлаас нь хамааран тодорхой нэг зоогийн газарт тогтмол цагуудад үйлчлүүлэхээр хуваарилдаг бөгөөд ажилтнууд хооллох газрынхаа байршил болон цагийг солих бол Кэмп, Уурхайн талбарын үйлчилгээний хэлтэст хүсэлт гаргана.

14.4. Хоолны цагийг нарийн баримтлах бөгөөд яаралтай үед илүү цагаар ажилласан болон хүндэтгэх шалтгаантай нөхцөл үүссэнээс бусад тохиолдолд тогтоосон цагаас бусад цагт хоолоор үйлчлэхгүй.

14.5. Үйлчлүүлэгчид нь зоогийн газраар үйлчлүүлэхдээ нэвтрэх үнэмлэхээ уншуулах ба үнэмлэх нь хүчингүй тохиолдолд нэвтрэхийг хориглоно.

14.6. Зоогийн газраар үйлчлүүлэхдээ хүн бүр эрүүл ахуй, аюулгүй байдлаа ханган, цэвэр хувцасласан байвал зохино. Гал тогоо, зоогийн газрын үйлчилгээг хэвийн явуулахад дөхөм болох үүднээс үйлчлүүлэгч нь зоогийн газрын үйлчилгээний ажилтнуудад ажил үүргээ гүйцэтгэхэд нь тусалж дэмжвэл зохино. Үйлчлүүлэгч нь халуун хоол, цайгаа өөрийн болон бусдын эрүүл мэнд аюулгүй байдалд эрсдэл үүсгэхгүйгээр зөөж хэрэглэнэ.

14.7. Жимснээс бусад хоол хүнс, аливаа сав суулга, хоолны хэрэгслийг зоогийн газраас авч гарахыг хориглоно.

14.8. Савласан хоолыг зөвхөн зөвшөөрөл бүхий ажилтнуудад бэлтгэж өгнө. Ажилтан нь ажлын шаардлагын улмаас зоогийн газарт үдийн хоол идэх боломжгүй тохиолдолд энэ талаар 2-оос доошгүй хоногийн өмнө урьдчилан хүсэлт гаргах ба энэ хүсэлтийг үндэслэн гал тогооноос хоолыг нь авч явахаар савлан бэлтгэж өгнө.

14.9. Хоол хүнс хадгалах зориулалтын төхөөрөмжгүй байранд хоол болон түргэн муудах аливаа хүнс хадгалахыг хориглоно.

## **15. Эрүүл мэнд, эрүүл ахуй**

15.1. Компани нь уурхайн талбарт байрлаж буй ажилтнууд болон зочдын эрүүл мэндэд анхаарал тавих үүрэгтэй. Үүнтэй холбоотойгоор анхны тусламжийн хайрцгуудыг хэд хэдэн газарт байрлуулах ба уурхайн талбарт байрладаг СОС эмнэлгээс эрүүл мэндийн зөвлөгөө, тусламж үйлчилгээг авах боломжтой.

15.2. Бүх барилга байгууламжид, тэр дундаа ариун цэврийн өрөөнүүдэд тогтмол цэвэрлэгээ хийж, эрүүл ахуйг сахина. Кэмпид байрлах ажилтан болон зочин нь эрүүл ахуйн шаардлага хангахгүй аливаа нөхцлийг мэдсэн тохиолдолд Кэмп, Уурхайн талбарын үйлчилгээний хэлтэст мэдээлнэ.

15.3. Кэмпид байрлах ажилтнууд болон зочид нь хувийн ариун цэврийг дээд зэргээр сахиж (Ариун цэврийн өрөөг ашигласны дараа гараа угаах, ханиах, найтаахдаа ам хамраа дарах), нийтийн зориулалттай газрыг цэвэр байлгах үүрэгтэй. Шүлсээ хаях, зориулалтын бус газар бие засах, суултуурын гадуур болон усны сав зэрэг бусад саванд бие засах гэх мэт эрүүл ахуйд нийцэхгүй байдал гаргахыг хориглоно.

15.4. Ямар нэг халдварт өвчний бодит эсхүл болзошгүй шинж тэмдэг илэрвэл СОС эмнэлэгт нэн даруй мэдэгдэнэ.

15.5. Уурхайн талбарт зөвхөн зөвшөөрөгдсөн цэгүүдэд тамхи татахыг зөвшөөрнө. Тамхи татах цэгүүдээс бусад газар болох байр, нийтийн эзэмшлийн газрууд, оффис, бие засах газрууд, тээврийн хэрэгсэл гэх мэт газруудад тамхи татахыг хориглоно.

## **16. Аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал**

### **16.1. Ерөнхий зүйл**

16.1.1. Уурхайн талбарт аюулгүй байдал, аюулгүй ажиллагааг бүх түвшинд хангах явдал нь нэн тэргүүний чухал асуудал ба ийнхүү хангаснаар тэнд байрлах ажилтнууд болон зочид нь уурхайн талбарын орчинд болон зөвшөөрөгдсөн газруудад чөлөөтэй зорчиж, ажил үүргээ амар тайван гүйцэтгэх боломжийг бүрдүүлнэ.

### **16.2. Уурхайн талбарт оруулахыг хориглосон зүйлс**

16.2.1. Дараах зүйлсийг Уурхайн талбарт оруулах, авч явах, эзэмшихийг хориглоно. Энэхүү шаардлагыг зөрчсөн тохиолдолд ноцтой зөрчилд тооцон компанийн ажилтанд ажлаас халах сахилгын шийтгэл ногдуулах ба компанийн ажилтнуудаас бусад ажилтнууд болон зочдын хувьд Уурхайн талбараас гаргах хүртэл арга хэмжээг авах үндэслэл болно. Үүнд:

16.2.1.1. Хутга, галт зэвсэг эсхүл бүх төрлийн зэвсгийн чанартай зүйлс (байлдааны уламжлалт хэрэгслийг оруулна);

16.2.1.2. Тэсэрч дэлбэрэх бодис,

16.2.1.3. Салют, бенгалын гал, цацруулагч буюу утаа гаргагч;

16.2.1.4. Цочруулагч хэрэгслүүд (цахилгаан буу, бороохой гэх мэт);

16.2.1.5. Ташуур;

16.2.1.6. Бие хамгаалах зориулалттай шүршигчүүд;

16.2.1.7. Гэрийн тэжээвэр болон бусад амьтан;

16.2.1.8. Бүх төрлийн химийн болон биологийн аюултай бодис;

16.2.1.9. мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис;

16.2.1.10. Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хэрэглэхэд ашигладаг хэрэгсэл;

16.2.1.11. Согтууруулах ундаа, айраг, бүх төрлийн исгэсэн ундаа;

16.2.1.12. Хориглосон эд зүйлсийг дуурайлган хийсэн зэвсгийн чанартай зүйлс (тоглоомон буу, гранат зэрэг).

16.2.2. Зэвсгийн чанартай спортын хэрэгсэл, бэлэг дурсгалын зүйлсийг Кэмп, Уурхайн талбарын үйлчилгээний хэлтэст бүртгүүлэн нэвтрүүлж, зөвхөн зөвшөөрөгдсөн газарт хэрэглэж болно (нум сум гэх мэт).

16.2.3. Эрүүл ахуй, аюулгүйн үүднээс дараах түргэн мууддаг хүнсний зүйлсийг уурхайн талбарт оруулах, ашиглахыг хориглох ба эдгээрийг хураан авч устгана. Үүнд:

16.2.3.1. Түүхий мах болон цаашид дахин боловсруулах шаардлагатай мах, махан бүтээгдэхүүн;

16.2.3.2. Түүхий өндөг, түүхий сүү гэх мэт.

### **16.3. Тээврийн хэрэгсэл жолоодох**

16.3.1. Уурхайн талбарт байрлаж буй хүмүүсийн аюулгүй байдлыг хангах зорилгоор тээврийн хэрэгсэл, тэдгээрийг жолоодохтой холбоотой уурхайн талбарт баримтлах бодлого, дүрэм, журам, стандартуудыг байнга дагаж мөрдөнө. (“СЗ Тээврийн хэрэгсэл ба Жолоодлогын журам”). Үүнд:

16.3.1.1. Тээврийн хэрэгсэл жолоодох хүн бүр Монгол Улсад болон уурхайн талбарт жолоо барих хүчин төгөлдөр үнэмлэхтэй байх;

16.3.1.2. Жолооч, зорчигч нар суудлын бүсийг байнга зүүх;

16.3.1.3. Уурхайн талбар доторх зам болон уурхайн орчинд хурдны зөвшөөрөгдсөн хязгаар, тэмдэг тэмдэглэгээ, замын хөдөлгөөний дүрмийг баримтлах;

16.3.1.4. Тээврийн хэрэгслүүдийг зөвхөн зориулалтын, тэмдэглэгээ бүхий зогсоолуудад байрлуулах;

16.3.1.5. Жолоо барих үед гар утас ашиглах буюу утсаар ярих, бичих, оролдох мөн тамхи татах болон аюулгүй ажиллагаанд саад болох, анхаарал сарниулах бусад үйлдлийг хориглоно.

16.3.2. Энэ журмын 16.3.1-д заасан аль нэг шаардлагыг дагаж мөрдөөгүй, зөрчсөн тохиолдолд компанийн ажилтанд зохих сахилгын шийтгэл ногдуулах ба компанийн ажилтнуудаас бусад ажилтнууд болон зочдын хувьд Уурхайн талбараас гаргах хүртэл арга хэмжээг авна.

16.3.3. Монгол Улсын Замын хөдөлгөөний аюулгүй байдалтай холбогдох хууль тогтоомж зөрчин аливаа зөрчил гаргасан тохиолдолд аюулгүй байдлын хэлтэс нь холбогдох эрх бүхий хуулийн байгууллагад мэдээлнэ.

## **16.4. Аюулгүй байдал**

16.4.1. Уурхайн талбарт байх хугацаандаа Компаниас олгосон ажилтны үнэмлэх эсхүл зочны үнэмлэхийг байнга зүүж явна.

16.4.2. Үнэмлэхийг аюулгүй ажиллагааны болон уурхайн талбарын хамгаалалтын албаны ажилтнуудын шаардсан үед үзүүлнэ. Ажилтны эсхүл зочны үнэмлэхгүй тохиолдолд Уурхайн талбарт нэвтрүүлэхээс татгалзана. Ажилтны эсхүл зочны үнэмлэхгүй уурхайн талбарт нэвтэрсэн, шаардсан үед үзүүлээгүй тохиолдолд уурхайн талбараас шууд гаргах арга хэмжээ авна.

16.4.3. Уурхайн талбар, тээврийн хэрэгсэл болон нисэх буудал дээр хяналтын камер, хяналтын бусад төрлийн электрон төхөөрөмжүүдийг байнга ажиллуулна. Эдгээр төхөөрөмжид хураагдсан бичлэг болон мэдээллийг сахилгын, аюулгүй ажиллагааны болон хяналт шалгалтын бусад арга хэмжээг авахад баримт болгон ашиглахаас гадна шаардлагатай гэж үзвэл хууль сахиулах болон төрийн бусад байгууллагад шилжүүлэн өгч болно.

16.4.4. Аюулгүй байдал хариуцсан хэлтэс нь ачаа тээш, орон байр, оффис, тээврийн хэрэгсэл, ажлын байранд төлөвлөсөн болон гэнэтийн хяналт шалгалт хийж болно.

16.4.5. Компани нь холбогдох хууль, зохицуулалтын зөвшөөрөгдсөн хүрээнд орон байр болон өрөө/ гэрт аюулгүй байдал болон аюулгүй ажиллагааны хяналт шалгалтыг явуулах эрхтэй.

16.4.6. Орон байр болон өрөө/ гэрт дараах зорилгоор хяналт шалгалтыг хийнэ:

16.4.6.1. Ажилтан, гэрээт компанийн ажилтан болон зочдын аюулгүй байдлыг хангах;

16.4.6.2. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх;

16.4.6.3. Сөгтууруулах ундааны зүй бус хэрэглээнээс урьдчилан сэргийлэх.

16.4.7. Хяналт шалгалтыг хийхдээ хүний эрх, хувийн нууцыг хүндэтгэх бөгөөд хууль, дүрэм журмын хүрээнд явуулна.

16.4.8. Хориглосон болон хулгайлагдсан аливаа эд зүйлсийг хураан авах ба хориглосон эд зүйлсийг холбогдох эзэн нь буцаан авахаас татгалзсан тохиолдолд устгана. Аюулгүй ажиллагаа, аюулгүй байдал хариуцсан хэлтсээс хяналт шалгалт болон хураан авсан эд зүйлсийн тухай тэмдэглэл хөтөлж, зөрчил гаргасан ажилтны харьяалагдах хэлтсийн удирдах ажилтан болон Хүний нөөц хариуцсан хэлтэст мэдэгдэнэ. Гэмт хэргийн шинжтэй үйлдэл, хууль бус эд зүйлс илэрсэн тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.



16.4.9. Хяналт шалгалт хийлгэхээс татгалзсан тохиолдолд уурхайн талбараас гаргана.

16.4.10. Хувийн болон компанийн өмч хөрөнгө алга болсон, эвдэрсэн эсхүл хулгайлагдсан бол мэдсэн даруйдаа Аюулгүй байдал хариуцсан хэлтэст мэдэгдэнэ.

16.4.11. Нэг буюу хэсэг бүлэг хүмүүс уурхайн талбарт буй бусад байрлагсад саад, төвөг учруулж байгаа тохиолдолд Онцгой байдлын хяналтын өрөө рүү даруй утасдан мэдэгдэнэ. Тухайн хүн буюу бүлэг хүмүүс согтууруулах ундаа хэрэглэж, Кэмгийн амар тайван байдлыг алдагдуулж байгаа үед Кэмпид байрлах ажилтан эсхүл зочин нь ямар ч тохиолдолд тухайн хүмүүс рүү очиж асуудлыг шийдэхийг оролдох ёсгүй.

## **16.5. Онцгой байдал**

16.5.1. Онцгой нөхцөл байдал үүссэн тохиолдолд Уурхайн талбарт байрлах ажилтан, зочин нь Онцгой байдлын хяналтын өрөөний 9904 3333 дугаараар холбогдоно. Уг дугаар нь 24 цагаар ажилладаг тул яаралтай, онцгой байдал үүссэн гэж үзсэн тохиолдол бүрт уурхайн талбар, кэмп, Улаанбаатар хотын ажилтнууд уг дугаарт холбогдоно.

16.5.2. Хяналтын баг нь 7 хоногийн өдөр бүр 24 цагаар ажиллана. Онцгой нөхцөл байдал үүссэн үед бүх ажилтнууд тухайн баг хэлтсийг хариуцсан галын идэвхтэнүүд болон Онцгой байдлын үеийн зохицуулалт хариуцсан ажилтнуудын зааврыг дагах үүрэгтэй. Үүнд: галын дохиолол идэвхжсэн үед нүүлгэн шилжүүлэлтэнд заавал хамрагдаж цуглах цэгт очно.

16.5.3. Кэмпид байрлах ажилтан болон зочин нь галын аюулаас урьдчилан сэргийлэх бүх талын арга хэмжээг авах үүрэгтэй. Үүнд:

16.5.3.1. Зөвшөөрөөгүй газар тамхи татахгүй байх, тамхины ишийг зориулалтын саванд бүрэн унтрааж хийх. Тамхинаас үүдэн гал гарахааргүй байх бүх нөхцлийг хангах;

16.5.3.2. Ил задгай гал гаргахгүй байх;

16.5.3.3. Лаа, зул, арц, хүж гэх мэт гал гарч болзошгүй зүйлийг ашиглахгүй байх;

16.5.3.4. Цахилгааны залгуурт хэт олон зүйл залгаж ачааллыг хэтрүүлэхгүй байх;

16.5.3.5. Өрөө /гэрт албан ёсоор тавьж өгсөнөөс бусад гал тогооны цахилгаан хэрэгсэл ашиглахгүй байх.

16.5.4. Дээр дурдсан зүйлсээс гадна Кэмп, Уурхайн талбарын үйлчилгээний хэлтсээс урьдчилан зөвшөөрөл авахгүйгээр аюултай эсхүл амархан шатах, гал авалцах материалыг өрөө/гэрт хадгалахыг хориглоно.

16.5.5. Агаар чийгшүүлэгч хэрэгсэл ашиглах нь галын дохиоллыг ажиллуулж болзошгүй тул өрөө/ гэртээ зохистойгоор хэрэглэнэ.

16.5.6. Гал унтраах хэрэгслийг Кэмпид байрлах ажилтнууд болон зочдын аюулгүй байдлыг хангах зорилгоор олгодог. Тогтоосон газруудад байрлуулсан гал унтраах хэрэгслийг зөвхөн зориулалтын дагуу ашиглана.

## **17. Холбоо барих утасны дугаар**

17.1. Кэмийн үйлчилгээ болон шаардлагатай утасны дугаарыг Кэмийн лавлах үйлчилгээний дугаар болох 95099575; 6868 дугаарт залган лавлан асууж болно.

## **18. Үүрэг, хариуцлага**

### **18.1. Ажилтны үүрэг**

18.1.1. Ажилтан нь уурхайн талбарт биеэ авч явахдаа бусад бүх хүмүүсийн адил аюулгүй байдлаа хангаж ажиллах, кэмпид байрлагсдын амар тайван амрах эрхийг зөрчихгүй байх үүрэгтэй. Ажилтан бүр дараах үүргийг хүлээх ба үүгээр хязгаарлагдахгүй. Үүнд:

18.1.1.1. Энэхүү журамтай уншиж танилцан, ойлгож, хэрэгжүүлэн дагаж мөрдөх;

18.1.1.2. Кэмпид байрлагсдад болон бизнесийн аливаа үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөргүй, зүй зохистой байдлаар биеэ авч явах;

18.1.1.3. Нисэх болон тээврийн үйлчилгээний журам, аюулгүй байдлын шалган нэвтрүүлэх журмыг дагаж мөрдөх;

18.1.1.4. Уурхайн талбарт ирэх болон буцахдаа бүртгүүлэх;

18.1.1.5. Үнэмлэхээ байнга биедээ авч явах;

18.1.1.6. Уурхайн талбарт нэвтрэхэд шаардлагатай бүх сургалтанд хамрагдах;

18.1.1.7. Уурхайн талбарт аливаа шатаар явахдаа шатны бариулыг заавал хэрэглэх;

18.1.1.8. Байрлаж буй өрөө/гэрээ цэвэр, аюулгүй байлгах;

18.1.1.9. Эрэгтэй ажилтнууд эмэгтэй ажилтнуудын байр, өрөө/гэрт нэвтрэхгүй, эмэгтэй ажилтнуудын байрны орчмоор сэлгүүцэхгүй байх;

18.1.1.10. Зоогийн газраар үйлчлүүлэхдээ хооллох цагийг нарийн чанд баримтлан, аюулгүй, эрүүл ахуйд нийцсэн байдлаар, цэвэр хувцаслах;

18.1.1.11. Хувийн ариун цэврийг дээд зэргээр сахих;

18.1.1.12. Зөвхөн зөвшөөрөлтэй газар тамхи татах;

18.1.1.13. Уурхайн талбарт нэвтрүүлэхийг хориглосон зүйлс авчрахгүй байх;

18.1.1.14. Хувийн болон компанийн өмч хөрөнгө алга болсон, эвдэрсэн эсхүл хулгайлагдсан мөн аюулгүй байдалд учирч болох аливаа эрсдлийг мэдсэн даруйдаа мэдэгдэх;

18.1.1.15. Мансууруулах бодис ба согтууруулан ундааны хэрэглээг зохицуулах журмыг дагаж мөрдөх;

18.1.1.16. Энэхүү журмыг зөрчсөн, зөрчсөн байж болох эсхүл зөрчиж болзошгүй байгаа тохиолдолд мэдэгдэх.

## **18.2. Удирдах ажилтны үүрэг**

18.2.1. Бүх удирдах ажилтнууд нь өөрийн удирдлаганд ажиллаж буй ажилтнуудынхаа эрүүл мэнд, аюулгүй байдал, амгалан тайван байдал хангагдаж байгаа эсэхэд анхаарал тавин ажиллана. Удирдах ажилтнууд нь дор дурдсан тодорхой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Үүнд:

18.2.1.1. Өөрийн хариуцдаг баг, хэлтэс, албаны ажилтнуудад энэхүү журмыг танилцуулах мэдээлэл хийж шаардагдах сургалтанд бүрэн хамруулж, журмын хэрэгжилтэнд хяналт тавих;

18.2.1.2. Ажилтнуудын эрүүл мэнд, аюулгүй ажиллагаа, аюулгүй байдалд эрсдэл учирвал асуудлыг мэдэгдэх, шийдвэрлэх эсхүл эрсдлийг бууруулах арга хэмжээг нэн даруй авах;

18.2.1.3. Энэхүү журмыг зөрчсөн, зөрчсөн байж болох эсхүл зөрчиж болзошгүй байгаа тохиолдолд даруй мэдэгдэх, арга хэмжээ авах.

## **18.3. Гэрээт компани болон бусад этгээдийн үүрэг**

18.3.1. Бүх байгууллага, хувь хүн нь өөрийн болон өөрийн удирдлаганд ажиллаж буй ажилтнуудынхаа эрүүл мэнд, аюулгүй байдал, амгалан тайван байдлыг хариуцан ажиллана. Үүнд дор дурдсан үүргийг хүлээнэ:

18.3.1.1. Хариуцан ажиллаж буй ажилтнууддаа уурхайн талбарт ирэхээс нь өмнө эсхүл ирсэн даруйд нь энэхүү журмыг танилцуулах мэдээлэл хийж, шаардагдах сургалтанд бүрэн хамруулж, журмын хэрэгжилтэнд хяналт тавих.

## III Хавсралт

### 19. Нэр томъёо

19.1. Уг журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно. Үүнд:

19.1.1. **Ажилтан** гэж Оюу толгойн уурхайн талбар, нисэх буудал болон бусад холбогдох барилга байгууламж, байранд ажил үүрэг гүйцэтгэж, байрлаж, түр буудаллаж эсхүл үйлчлүүлж байгаа Компанийн ажилтнууд (Үүнд: дадлагажигч орно), гэрээт компанийн ажилтнууд болон гэрээлэгчийг;

19.1.2. **Зочин** гэж Оюу толгой ХХК-ийн зөвшөөрөл эсхүл хуулийн шаардлагын дагуу уурхайн талбарт түр хугацаагаар ажиллаж, байрлаж буй хүнийг;

19.1.3. **Кэмп** гэж байрлагсдын амьдрах байр, хоолны газар, амралт чөлөөт цаг өнгөрүүлэх газар, үйлчилгээний газрууд, спорт заал болон кэмгийн хашаа орчмын бусад сул чөлөөтэй газрыг;

19.1.4. **Онцгой нөхцөл байдал** гэж дараах нөхцөл байдлыг ойлгоно. Үүнд

- Амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгө, байгаль орчинд шууд аюул учруулах нөхцөл байдал;
- Амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгө, байгаль орчинд хохирол учруулсан нөхцөл байдал;
- Амь нас, эрүүл мэнд, өмч хөрөнгө болон байгаль орчинд шууд аюул учруулахад хүргэж болохуйц нөхцөл байдал.

19.1.5. **Уурхайн талбар** гэж Оюу Толгой уурхайн талбар дах бүх газрыг хамруулна. Үүнд: уурхайн талбар дах кэмп, ажлын байр, байгууламж, зорчих хэсэг, бусад сул чөлөөтэй газар гэх мэтийг ойлгоно.

### 20. Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж

20.1. Энэхүү журамтай холбогдуулан дараах Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журмыг авч үзсэн бөгөөд эдгээрийн үзэл санаа уг журамд тусгагдсан болно.

- Монгол Улсын Үндсэн хууль, 1992;
- Хөдөлмөрийн тухай хууль, 1999;
- Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн тухай хууль, 2008;
- Иргэний хууль, 2002;

- Галын аюулгүй байдлын тухай хууль, 2015;
- Хөдөлмөрийн тухай хуулийн зарим зүйл, заалтыг тайлбарлах тухай Улсын Дээд Шүүхийн 33 дугаар тогтоол, 2006.



## 21. Журамд холбогдох мэдээлэл

<b>Журмын нэр</b>	ХН-Ж7.1: Кэмпийн дотоод журам, ёс зүйн дүрэм
<b>Тодорхойлолт</b>	Энэхүү журмын зорилго нь Оюу Толгойн уурхайн талбар, кэмпүүдэд аюул осолгүй, найдвартай, эерэг найрсаг, тааламжтай орчныг бүрдүүлэхэд оршино.
<b>Эхийг зохиогч</b>	Николас Сандерс
<b>Боловсруулсан огноо</b>	2012-10-27

### Нэмэлт өөрчлөлт

Өөрчилсөн хувилбар	Огноо	Хянасан албан тушаалтан	Нэмэлт өөрчлөлтийн тэмдэглэл
1	2012-12-06	Николас Сандерс	Дахин хянаж, зохих өөрчлөлтийг оруулсан.
2	2017-10-30	Л.Мөнх-Оргил С.Надя	Дахин хянаж, зохих өөрчлөлтийг оруулсан.
3	2017-10-30	Л.Мөнх-Оргил С.Надя	Журмын нэрийг өөрчилж, зохих өөрчлөлтийг оруулсан.

### Батлах тухай

Огноо	Албан тушаал	Гарын үсэг	Компанийн тамга
2017-10-30	<u>Бодлогын баримт бичгийн өмчлөгч:</u> Боловсон хүчин, бүтэц зохион байгуулалт хариуцсан Ерөнхий менежер Майкл Гавин		
2017-10-30	<u>Журам баталсан:</u> Оюу толгой ХХК-ийн Гүйцэтгэх захирал Армандо Торрес	